

**“МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БОДЛОГО, ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Монгол Улсын төрийн бодлого, түүхэн уламжлал”
- ✓ **Зорилго:** Монгол Улсын төрийн бодлогын түүхэн уламжлалыг үечлэн төрөөс “төр, төрийн алба, түшмэл, иргэн хоорондын шүтэлцээг” хэрхэн тодорхойлон уламжилж ирсэн талаарх цэгцтэй ойлголт эзэмшүүлнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** Монгол Улсын төрийн бодлогын түүхэн үечлэл; Монгол Улсын төрийн бодлого дахь төр, төрийн алба, түшмэл, иргэн хоорондын шүтэлцээ; Монгол Улсын төрийн бодлогын түүхэн уламжлал ба нутгийн өөрийн удирдлага

Сэдэв 1. Монгол улсын төрийн бодлогын түүхэн үечлэл

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Монгол Улсын төрийн бодлогын уламжлал, сургамжийг түүхэн онцлох үе бүрээр тодруулан таниулах. Монгол Улсын улс төрхт төлөв байдлын үүсэл, хөгжил, түүнийг хадгалахад төрийн бодлого ямар үүрэгтэйг тодорхойлон нутгийн удирдлагын агуулгын хүрээнд тодруулан тайлбарлана.

Сэдэв 2. Монгол Улсын төрийн бодлого дахь төр, төрийн алба, түшмэл, иргэн хоорондын шүтэлцээ

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс жишээ

Сэдвийн агуулга: Монгол Улсын төрийн төр, албаны талаар явуулж ирсэн төрийн бодлого, төрийн албанд түшмэдийг бэлтгэж, ажиллуулах, чадваржуулах талаарх бодлогыг уламжлал, сургамжийн логикоор багцалж хичээлийн агуулгаар таниулах

Сэдэв 3. Монгол Улсын төрийн бодлогын түүхэн уламжлал ба нутгийн өөрийн удирдлага

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс жишээ

Сэдвийн агуулга: Төрийн бодлогын уялдаа холбоо, залгамж чанарыг хадгалах, төвийн болон орон нутгийн бодлогын нийлэмж, зөрчил, түүхэн сургамжийн талаар тодорхой үеүүдийн бодлогын алдаа доголдол, төвөөс зугтаах хүчин зүйлс, төвд тэмүүлэх хүчин зүйлсийн уялдаа зөрчлийг жишээ баримтад тулгуурлан тайлбарлана.

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага/кейс, жишээ
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Энэхүү хичээлийг үзсэний дараагаар дараах хичээлүүдээс сонгон судлах нь оновчтой. Үүнд:
 - Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт
 - ИТХ-ын төлөөлөгчийн ёс суртахууны төлөвшил
 - Бусад бодлоготой холбоотой хичээлүүд

**“ОРОН НУТГИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт”
- ✓ **Зорилго:** Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар цэгцтэй мэдлэгт суралцаж, Үндэсний түвшинд тодорхойлсон бодлогыг орон нутгийн түвшинд, орон нутгийн онцлогт нийцүүлэн уялдуулан төлөвлөх арга зүйд суралцана.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт; Үр дүнд суурилсан төлөвлөлтийн үндсэн ойлголт, арга зүй; Үндэсний түвшинд тодорхойлсон бодлогыг орон нутгийн түвшинд, бүс, орон нутгийн онцлогт нийцүүлэн уялдуулан төлөвлөх арга зүй

Сэдэв 1. Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн эрх зүйн орчны өнөөгийн байдал, гол үзэл баримтлалын талаарх мэдлэгт суралцана.

Сэдэв 2. Үр дүнд суурилсан төлөвлөлтийн үндсэн ойлголт, арга зүй

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Үр дүнд суурилсан төлөвлөлтийг нэвтрүүлэх арга зүй, орон нутагт хэрэгжүүлэхэд гол анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийг тайлбарлан, хэрэгжүүлэх мэдлэгт суралцана.

Сэдэв 3. Үндэсний түвшинд тодорхойлсон бодлогыг орон нутгийн түвшинд, бүс, орон нутгийн онцлогт нийцүүлэн уялдуулан төлөвлөхөд ИТХ-ын үүрэг, оролцоо

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Үндэсний болон орон нутгийн бодлого, төлөвлөлтийн уялдаа, арга зүй, эрх зүйн зохицуулалт, орон нутгийн төлөвлөлтийн үйл явцад ИТХ-ын үүрэг, эрх, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замын талаарх мэдлэг, ур чадварт суралцана.

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага/кейс, жишээ
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Энэхүү хичээлийг үзэхээс өмнө дараах хичээлүүдийг сонгон судлах нь оновчтой. Үүнд:

- Монгол Улсын төрийн бодлого, түүхэн уламжлал
- Орон нутгийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах нь
- Өгөгдөл мэдээллийг орон нутгийн төлөвлөлтөд ашиглах арга зүй

Энэхүү хичээлийг үзсэний дараагаар дараах хичээлүүдээс сонгон судлах нь оновчтой. Үүнд:

- Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлага
- Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй
- Орон нутгийн бодлогын үнэлгээ хийх арга зүй

**“ОРОН НУТГИЙН ТӨСӨВ: ТӨЛӨВЛӨХ, БАТЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Орон нутгийн төсөв: төлөвлөх, батлах, хяналт тавих
- ✓ **Зорилго:** Төв ба орон нутгийн төсвийн харилцааны талаар мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Төсвийн харилцааны үндсэн зарчмууд

Ногдох цаг: 1 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдэв 2. Чиг үүргийн хуваарилалт

Ногдох цаг: 1 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдэв 3. Төсвийн орлогын хуваарилалт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдэв 4. Төсөв хоорондын шилжүүлгийн тогтолцоо

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдэв 5. Орон нутгийн зээллэг

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Ярилцлага, бүлгийн ажил, хэлэлцүүлэг, кейс, дасгал, тест ажиллах

Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо: Суурь түвшний модульд багтсан хөтөлбөр бөгөөд “Орон нутгийн эдийн засгийн төлөвлөлт”, “Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт”, хөтөлбөрүүдтэй уялдана. Харин уг хөтөлбөрийг судалсны дараа “Орон нутгийн төсөв, төлөвлөх, гүйцэтгэлийг хянах арга зүй” хөтөлбөрийг гүнзгийрүүлэн судлах боломжтой.

“ОРОН НУТГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Орон нутгийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт
- ✓ **Зорилго:** Орон нутгийн түвшинд хүний нөөцийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд ИТХ-ын төлөөлөгчдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдлэг ур чадвар эзэмшүүлэх
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, нарийн бичгийн дарга, ИТХ-ын ажлын албаны ажилтнууд
- ✓ **Агуулга:**
 - Сэдэв 1. Төрийн албаны хүний нөөцийн бодлого, орон нутгийн хүний нөөцийн бодлого: ИТХ-ын үүрэг, оролцоо**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: лекц, ярилцлага
 - Сэдвийн агуулга:** Төрийн албаны хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн талаар үндсэн ойлголт, Орон нутгийн түвшин дэхь хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, ИТХ, ИТХ-ын төлөөлөгчийн үүрэг, оролцоо
 - Сэдэв 2. Орон нутгийн хүний нөөцийн өнөөгийн байдалд шинжилгээ хийх нь**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: лекц, ярилцлага
 - Сэдвийн агуулга:** Орон нутгийн түвшин дэх хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох нь, Орон нутгийн түвшинд хүний нөөцийн хангалт: бодлого, зохицуулалт
 - Сэдэв 3. Орон нутагт хүний нөөцийг чадавхжуулах бодлого**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: лекц, ярилцлага
 - Сэдвийн агуулга:** Төрийн албаны сургалтын бодлого: Орон нутгийн түвшинд, Орон нутгийн онцлогт нийцүүлэн хүний нөөцийг чадавхижуулах боломж, хэрэгцээ шаардлага
 - Сэдэв 4. Орон нутаг дахь хүний нөөцийг тогтвортой ажиллуулах бодлого**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: лекц, ярилцлага
 - Сэдвийн агуулга:** Төрийн алба тогтвортой байх зарчим: Орон нутгийн түвшинд анхаарах асуудлууд, Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах асуудлууд
- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** ИТХ-ын төлөөлөгч, ИТХ-ын ажлын албаны ажилтнуудад зориулсан суурь сургалт
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага хэлбэрээр тухайн орон нутгийн түвшин дэх төрийн албан хаагчийн хүний нөөцийн статистик мэдээлэлд тулгуурлан хичээлийг явуулна
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Орон нутгийн бодлого, төлөвлөлт, Орон нутгийн стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй, ИТХ-ын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт хичээлийг заавал үзсэн байна.

**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ, АРГА ТУРШЛАГУУД”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Бэлчээрийн менежмент, арга туршлагууд”
- ✓ **Зорилго:** Тухайн сэдвийн хүрээнд бэлчээрийн тухай үндсэн ойлголт, тодорхойлолт, бэлчээрийн менежмент, тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох мэдлэг ур чадварыг эзэмшүүлэх
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Бэлчээрийн менежментийн тухай үндсэн ойлголт

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Бэлчээрийн тухай үндсэн ойлголт, бэлчээрийн менежментийн тухай, монгол орны бэлчээрийн менежментийн тулгамдсан асуудал, бэлчээрийн менежментийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замууд

Сэдэв 2. Бэлчээрийн менежментийн арга туршлагууд

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Нүүдлийн мал аж ахуйн зохистой дадлын стандартыг нэвтрүүлснээр бэлчээрийн менежментийг сайжруулах

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин (төлөөлөгчдөд бүрэн эрхийн хугацааны эхэнд, эсвэл Хурлын ажлын албаны ажилтнуудад шинээр томилогдсоны дараа гэх мэт) ахисан түвшин (байгаль орчин, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил хариуцсан хорооны төлөөлөгчид, ажлын хэсэг гэх мэт)
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, семинар, ярилцлага, мэтгэлцээн, кейс дасгал ажиллах, багаар ажиллах, танин мэдэхүйн болон идэвхтэй оролцооны аргад тулгуурлах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Тухайн хөтөлбөрийг судлахын өмнө заавал үзэж судалсан байх ямар нэг шаардлага тавигдахгүй болно. Сургалтын явцад холбогдох гарын авлага, илтгэлийг бэлтгэж өгөх учраас оролцогчид цааш үргэлжлүүлэн судлах бүрэн боломжтой байх юм.

“ОРОН НУТГИЙН НИЙГМИЙН САЛБАРЫН БОДЛОГО, УДИРДЛАГЫН ҮНДЭС” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлагын үндэс
- ✓ **Зорилго:** Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлагын үндсийг хүний хөгжлийн үзэл баримтлалын үүднээс ойлгох, улмаар нийгмийн салбарын бодлого, удирдлагыг сайжруулахад чиглэсэн бодлого, шийдвэр гаргах мэдлэг, чадвар эзэмшүүлэх
- ✓ **Зорилгот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**
 - Сэдэв 1.** Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлагын үндсэн ойлголт
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц
 - Сэдэв 2.** Хүн төвтэй, иргэнд ээлтэй нийгмийн салбарын бодлого, удирдлага
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц
 - Сэдэв 3.** Нийгмийн салбарын бодлого, үйлчилгээг хүний хөгжилд чиглүүлэх нь
 - Ногдох цаг: 4 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, дасгал, кейс
- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин
 - ИТХ-ын төлөөлөгчид орон нутгийн нийгмийн салбарын бодлого, байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх ажиллахад баримтлах үзэл баримтлал, тулгуур ойлголтын талаар мэдлэг эзэмших тул **суурь сургалт** болно.
- ✓ **Хичээлийн хэлбэр:**

Сургалтад олон талын оролцоог дэмжсэн, дараах аргуудыг ашиглана. Үүнд:

 - ... Лекц (Багшийн мэдээлэл, танилцуулга)
 - ... Асуулт, хариулт ба хэлэлцүүлэг
 - ... Бүлгийн ажил
 - ... Бодит кейс, жишээ
 - ... Видео
 - ... Сайн туршлага.
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа:** Хөтөлбөр нь “Та-Бодлого тодорхойлогч”, “Та-Иргэдийн төлөөлөгч”, “Та-Шийдвэр гаргагч” гэсэн чиглэлүүдэд илүүтэй холбогдоно. “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050” нь хүн төвтэй хөгжлийн бодлогын баримт бичиг тул нийт ИТХ-ын төлөөлөгчдөд тодорхой хэмжээгээр, нийгмийн асуудлыг хариуцдаг төлөөлөгчдөд шууд хамааралтай юм.

“АЛСЫН ХАРАА 2050” УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого “Шинэ сэргэлтийн бодлого”
- ✓ **Зорилго:** Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ыг хэрэгжүүлэх дунд хугацааны бодлогын үндэслэл, хамрах хүрээ, хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны талаарх ойлголтыг өгч, салбар болон байгууллагынхаа хувьд хэрхэн хувь нэмэр оруулах талаар суралцагчдын оролцоотойгоор арга замыг тодорхойлно.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Шинэ сэргэлтийн бодлогыг боловсруулах болсон үндэслэл, хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлс

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, Багийн ажил

Сэдвийн агуулга: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангахад тулгарсан бэрхшээл болон улсын хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг танилцуулж, санал солилцоно. Ингэхдээ оролцогчдыг багаар хувааж, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлуулж, цөөн хүчин зүйлс рүү нэгтгэн зангидаж хязгаарлагч хүчин зүйлсийг өөрсдөөр нь багцлуулна. Үүний дараа ШСБ-ын хязгаарлагч 6 хүчин зүйлсийг танилцуулна.

Сэдэв 2. Шинэ сэргэлтийн бодлогын зорилтууд

Ногдох цаг: 3 цаг

Хэлбэр: Лекц, Дасгал ажил

Сэдвийн агуулга: ШСБ-ийн хүрээнд дэвшүүлсэн 6 сэргэлтийн талаар танилцуулж, оролцогчдын орон нутаг, салбар, байгууллагатай холбоотой сэргэлтүүд, үйл ажиллагааг тодорхойлуулна. Батлагдсан төслүүдээс сонголт хийлгэнэ.

Сэдэв 3. ШСБ-ыг хэрэгжүүлэхэд бидний оролцоо

Ногдох цаг: 3 цаг

Хэлбэр: Багийн ажил

Сэдвийн агуулга: Танай байгууллага ШСБ-ийн аль сэргэлт, үйл ажиллагаанд хэрхэн оролцох вэ? Ямар байгууллагуудтай хэрхэн хамтарч ажилласнаар илүү үр дүнд хүрэх боломжтой вэ? гэсэн ерөнхий асуултын хүрээнд багуудаар ажиллуулж, бусаддаа танилцуулан, дүгнэнэ. Хамтын ажиллагаа, уялдаа холбоо чухал гэдгийг өөрсдөөр нь гаргуулж ирнэ.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага, багийн ажил **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Алсын хараа-2050 сургалт, Алсын хараа-2050 бодлогын Эдийн засгийн зорилтын агуулгыг үзсэн оролцогч энэхүү хичээлийг судалвал тохиромжтой.

**“АЛСЫН ХАРАА 2050” УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО “ЗАСАГЛАЛ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого “Засаглал”
- ✓ **Зорилго:** Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын засаглал зорилтын хүрэх үр дүн, зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, албан хаагчийн үүрэг оролцооны талаар мэдлэг, ойлголттой болох
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** Засаглал гэж юу вэ, засаглалын хэлбэр, засаглал зорилтын хүрэх үр дүн, өнөөгийн нөхцөл байдал

Сэдэв 1. Засаглал гэж юу вэ

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Засаглалын талаарх ойлголт, төрийн бодлого, үр дүн

Сэдэв 2. Амар тайван аюулгүй нийгэм, ногоон хөгжил

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Амар тайван аюулгүй нийгэм болон ногоон хөгжлийн зорилтууд

Сэдэв 3. Дасгал ажил

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Алсын хараа 2050 зорилт болон тулгамдаж буй асуудлыг тодорхойлох

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Ярилцлага, бүлгийн ажил, хэлэлцүүлэг, кейс, дасгал, тест ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Суурь түвшний модульд багтсан хөтөлбөр бөгөөд Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого “Шинэ сэргэлтийн бодлого”, Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого “Эдийн засаг, Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого “Хүний хөгжил”, “Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт”, хөтөлбөрүүдтэй уялдана.

**“АЛСЫН ХАРАА-2050” УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
“ЭДИЙН ЗАСАГ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Алсын хараа-2050 бодлогын Эдийн засаг”
- ✓ **Зорилго:** Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ыг боловсруулан хэрэгжүүлж буйг танилцуулаад Эдийн засгийн зорилгыг онол, практикт суурилан ойлгуулна. Гол нь оролцогчдын дунд тухайн салбар, байгууллагын зүгээс эдийн засгийн хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулах боломжтойг өөрсдөөр нь гаргаж ирнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Эдийн засгийн зорилго болон бусад зорилгын уялдаа

Ногдох цаг: 3 цаг

Хэлбэр: Лекц, Багийн ажил

Сэдвийн агуулга: Эдийн засгийн ерөнхий ойлголт, Монгол улсын өнөөгийн байдлыг ярилцаад Алсын хараа-2050-д тусгагдсан 6 зорилтын ерөнхий логик, уялдааг танилцуулна. Оролцогчдын дунд багийн ажил зохион байгуулж эдийн засгийн зорилготой уялдсан бусад зорилго, зорилтуудыг гаргаж, хэлэлцүүлнэ.

Сэдэв 2. Инновац, кластер болон эдийн засаг

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Дасгал ажил

Сэдвийн агуулга: Инноваци.

Сэдэв 3. Таны оролцоот эдийн засгийн хөгжил

Ногдох цаг: 3 цаг

Хэлбэр: Багийн ажил

Сэдвийн агуулга: Танай байгууллага ШСБ-ийн аль сэргэлт, үйл ажиллагаанд хэрхэн оролцох вэ? Ямар байгууллагуудтай хэрхэн хамтарч ажилласнаар илүү үр дүнд хүрэх боломжтой вэ? гэсэн ерөнхий асуултын хүрээнд багуудаар ажиллуулж, бусаддаа танилцуулан, дүгнэнэ. Хамтын ажиллагаа, уялдаа холбоо чухал гэдгийг өөрсдөөр нь гаргуулж ирнэ.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага, багийн ажил
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Алсын хараа-2050 сургалт, Алсын хараа-2050 бодлогын Эдийн засгийн зорилтын агуулгыг үзсэн оролцогч энэхүү хичээлийг судалбал тохиромжтой.

“АЛСЫН ХАРАА 2050” УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО “ХҮНИЙ ХӨГЖИЛ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого “Хүний хөгжил”
- ✓ **Зорилго:** “Алсын хараа-2050”-ын хүний хөгжлийг дэмжих бодлогын зорилго, зорилт, үндсэн чиглэл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, албан хаагчдын гүйцэтгэх үүргийг сурталчилан таниулах, бодлогын хэрэгжилт дэх оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх арга зүйн мэдлэг эзэмшүүлэх
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** - Хүний хөгжлийн прадигом, Монгол Улсын хүний хөгжлийн төлөв байдал - Боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөрийн зах зээл, шинжлэх ухаан инновац, гэр бүл, хүнд ээлтэй амьдрах орчин, Монгол хүний удмын сангийн өнөөгийн байдал, цаашдын төлөв
- Хүний хөгжлийг дэмжих чиглэлээр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, албан хаагчийн гүйцэтгэх чиг үүрэг, салбар дундын хамтын ажиллагааг хангах арга зам

Сэдэв 1. Хүний хөгжлийн тухай ойлголт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Хүний хөгжлийн үзэл баримтлал, хэмжүүр, Монгол Улсын хүний хөгжлийн төлөв байдал, цаашдын хандлага**Сэдэв 2. Хүний хөгжлийн бодлогын зорилго, хүрэх үр дүн**

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Монгол Улсын боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хөдөлмөрийн зах зээл, шинжлэх ухаан инновац, хүнд ээлтэй амьдрах орчин, удмын сангийн өнөөгийн төлөв байдал, Алсын хараа 2050-ын хүрээнд дэвшүүлсэн бодлогын зорилгыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн, үйл ажиллагаа**Сэдэв 3. Хүний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг хангах арга зам**

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Салбар дундын хамтын ажиллагааны тухай ойлголт, төрөл хэлбэр, хүний хөгжлийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг хангах арга зам

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага, кейс дасгал
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Монгол Улсын төрийн бодлого, түүхэн уламжлал, Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт, Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлага, Орон нутгийн салбар хоорондын бодлогын зохицуулалт

“НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС, ҮЙЛ АЖИЛЛАГАА” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагаа
- ✓ **Зорилго:** Нутгийн өөрийн удирдлагын тухай үндсэн ойлголт, НӨУБ-ын эрх зүйн үндэс, чиг үүрэг-үйл ажиллагааны онцлог, нутгийн захиргаа-нутгийн өөрийн удирдлагын харилцааны талаар онол арга зүйн мэдлэг олгоно.
- ✓ **Зорилтот бүлэг:** Сонгуулийн дараа зохион байгуулна. Голчлон шинэ сонгогдсон төлөөлөгчид болон бусад төлөөлөгчид, мөн хурлын ажлын албаны албан хаагчид судлах боломжтой.
- ✓ **Агуулга:** Ерөнхий болон дэд сэдэв бүрийн товч тодорхойлолт, агуулга, ноогдох цаг, заах хэлбэр

Сэдэв 1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс

Ноогдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга

Нутгийн өөрөө удирдах ёсны тухайн үндсэн ойлголт, Монгол Улсын төрийн удирдлагын тогтолцоо, нутгийн өөрийн удирдлагын байгууллага, түүний Үндсэн хуулийн баталгаа, эрх хэмжээг хамааруулан авч үзнэ.

Сэдэв 2. Иргэдийг төлөөлөгчдийн хурлын хуралдааныг зохион байгуулах

Ноогдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, багийн ажиллагаа

Сэдвийн агуулга

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэрүүд, хуралдааны дэг, төлөөлөгч болон ИТХ-ын шийдвэрийн талаар авч үзнэ.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага, багаар ажиллах, кейс дасгал-туршлага солилцох
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Тухайн хөтөлбөрийг судласны дараа “ИТХ-ын үйл ажиллагаа: зөвлөл, хороо, ажлын хэсэг, хуралдаан, зохион байгуулалт”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, шийдвэр гаргах үйл явц” сургалтуудаар гүнзгийрүүлэн судлах боломжтой.#

“ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ИМИЖ БҮРДҮҮЛЭЛТ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР”

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “ИТХ-ын төлөөлөгчийн имиж бүрдүүлэлт”
- ✓ **Зорилго:** ИТХ-ын төлөөлөгчийн имиж бүрдүүлэхэд тэдгээрийг практик үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ур чадвараа хөгжүүлнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Имижийн тухай ойлголт, имиж судлалын орчин үеийн чиг хандлага

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Имиж, улс төрийн имижийн тухай ойлголт, имиж судлалын орчин үеийн чиг хандлага. Хувь хүний имижийн тухай ойлголт, хувь хүний гадаад, сэтгэл зүйн болон нийгмийн дүр төрхийн тухай ойлголт. Имиж бүрдүүлэхэд имиж мейкерийн гүйцэтгэх үүрэг. Имиж бүрдүүлэх асуудлыг орчин үеийн улс төр ба засаглалын тухай шинэ хандлагатай уялдуулах нь.

Сэдэв 2. ИТХ-ын төлөөлөгчийн гадаад дүр төрх, түүнийг бүрдүүлэхэд анхаарах асуудлууд

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, кейс ажиллах

Сэдвийн агуулга: Гадаад дүр төрх, түүнд тавигдах шаардлага. Ажил хэрэгч хувцаслалт, түүний онцлог. “Хэт тансаглал, түүний сэтгэл зүйн сөрөг нөлөөлөл”. Имижийн бүрдэл хэсгүүд ажил хэргийн харилцаанд нэр хуудас хэрэглэх, утсаар ярих соёл.

Сэдэв 3. ИТХ-ын төлөөлөгчийн илтгэх болон олон нийттэй харилцах ур чадварыг хөгжүүлэх алхмууд

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: “Илтгэх ур чадвар, түүнд тавигдах шаардлага. Илтгэх ур чадварыг хөгжүүлэх алхмууд. Имиж бол сэтгэгдэл төрүүлж сэтгэл зүйг удирдах мэдрэмж болох тухай. Агуу бүхэн энгийн байдаг “Прэтфеллийн эффект” хэмээх ойлголтын тухай

Сэдэв 4. Сонгуульд нэр дэвшигчийн имиж бүрдүүлэхэд анхаарах асуудлууд

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Сонгуульд нэр дэвшигчийн имиж бүрдүүлэхэд анхаарах асуудлууд. Олон нийтийн хүлээлт ба нэр дэвшигчийн имиж. Улс төрийн намын мөрийн хөтөлбөр ба нэр дэвшигч. Олон нийттэй харилцахад гаргадаг түгээмэл алдаа, тэдгээрийг залруулахад анхаарах асуудлууд

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшний сургалтад зориулагдсан
- ✓ **Хичээлийн хэлбэр:**
 - Онолын мэдлэгийг товч лекц, ярилцлага хэлбэрээр олгоно.
 - Онолын мэдлэгийг практикт хэрэгжүүлэх чадвар эзэмшүүлэх зорилгоор кейс, дасгал ажиллах
 - Багаар хэлэлцүүлэг зохион байгуулж, харилцан суралцах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Энэ хичээлийг судлахын тулд “ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүй” хичээлүүдийг үзэж судалсан байх.

**“ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙ БА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүй ба ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”
- ✓ **Зорилго:** ИТХ-ын төлөөлөгчийн ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээний зохицуулалтын тухай ойлголтод түшиглэн ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвар эзэмшүүлнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээний зохицуулалт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц

Сэдвийн агуулга: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөд тавих ёс суртахууны хэм хэмжээ, үлгэрлэл; ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг зохицуулж буй хууль тогтоомж, ёс зүйн дүрэм, тэдгээрийг хэрэглэхэд анхаарах зүйлс, ёс зүйн алдаа ба зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

Сэдэв 2. Нийтийн ашиг сонирхол ба хувийн ашиг сонирхлын зөрчил: ойлголт, хамрах хүрээ, илрэх хэлбэрүүд

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Нийтийн ашиг сонирхол ба хувийн ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт, ИТХ-ын төлөөлөгчийн хувьд үүсч болох ашиг сонирхлын зөрчлийн хэлбэрүүд, түүнээс урдчилан сэргийлэх нь

Сэдэв 3. Ёс зүйн эргэлзээтэй нөхцөл байдал ба ёс зүйтэй шийдвэр гаргах нь

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдвийн агуулга: Ёс зүйн хоёрдмол байдал буюу эргэлзээтэй нөхцөл байдал үүсгэдэг хүчин зүйлс, түүний нөлөөлөл, ёс зүйтэй шийдвэр гаргах загвар, түүний хэрэглээ

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:**
 - Ёс зүйн хэм хэмжээ ба ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэгийг лекц, ярилцлага, хэлэлцүүлэг хэлбэрээр олгоно.
 - Жишээ, кейс, дасгал ажиллах, оролцооны арга ашиглан онолын мэдлэгийг практикт хэрэгжүүлэх чадвар эзэмшүүлнэ
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Дараах хичээлүүдтэй уялдсан байх ёстой. Үүнд
 - Улс төрчийн имиж бүрдүүлэлт,
 - Улс төрийн манлайлал,
 - Гадаад харилцаа дипломат ёс,
 - ИТХ-ын чиг үүрэг, үйл ажиллагааны зохион байгуулалт

“ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Хууль тогтоомжийн хэрэглээ”
- ✓ **Зорилго:** Хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ захиргааны алдаатай шийдвэр гаргахгүй байхаас урьдчилан сэргийлнэ
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** ИТХ-ын захиргааны байгууллага болох тухай, захиргааны шийдвэр гаргах ажиллагаа, шийдвэрийн хууль зүйн үндэслэлд хууль тогтоомжийг зөв эрэмбэлэх техникийг үзнэ.

Сэдэв 1. ИТХ захиргааны байгууллага болох тухай

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Захиргааны байгууллагын нийтлэг шинж ба ИТХ-ын эрх зүйн байдал, харилцан хамаарал

Сэдэв 2. ИТХ-аас гаргадаг захиргананы шийдвэр

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Захиргаанб акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээг батлах журам, эрх зүйн үндэслэл

Сэдэв 3. Захиргааны шийдвэрийн хууль зүйн үндэслэл

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Хуулиудын эрэмбэ, хууль зүйн техникийн талаар үзнэ.

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин, бататгах түвшин, ахисан түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** лекц, дасгал ажил
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагаа, Албан бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах арга зүй хөтөлбөрүүдтэй уялдана.

**“ОРОН НУТГИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД
ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр: Орон нутгийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах нь**
- ✓ **Зорилго:** ИТХ-ын шийдвэр гаргалтад иргэдийн оролцооны арга, хэлбэрүүдийг ашиглах мэдлэг чадвар эзэмшүүлэх
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ - ын төлөөлөгчид, ИТХ – ын дарга, нарийн бичгийн дарга, хурлын ажлын алба
- ✓ **Агуулга:** Шийдвэр гаргалтын үндсэн арга, шийдвэр гаргалтад оролцооны аргуудыг хэрэглэх, хэлэлцэх, Иргэдийн оролцоотой шийдвэр гаргах боломж, тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох

Сэдэв 1. ИТХ-ын шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах арга, хэлбэр

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, хэлэлцүүлэг, багаар ажиллах

Сэдвийн агуулга: Шийдвэр гаргалтын үндсэн аргууд, иргэдийн оролцоог хангах арга, хэлбэрүүдийн талаар үндсэн ойлголт, мэдлэгийг танилцуулж, ИТХ-ын шийдвэр гаргалтад оролцооны аргуудыг үр дүнтэй хэрэглэх боломжуудыг хэлэлцэж, харилцан туршлага солилцоно.

- ✓ **Сэдэв 2. Иргэдийн оролцоотой шийдвэр гаргах боломж, туршлага, сургамж**

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Багшийн лекц, орон нутгийн бодит кейсүүд дээр ажиллах

Сэдвийн агуулга: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангаж буй сайн туршлагаууд (*кейсүүд*)-тай танилцаж, иргэдийн оролцоотой шийдвэр гаргах боломж, туршлага, сургамж, тулгарч буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж хэлэлцэнэ.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, семинар, хэлэлцүүлэг, мэтгэлцээн, кейс, дасгал, багаар ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Хөтөлбөрийг судлахын өмнө суурь түвшний Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагаа, ИТХ-ын чиг үүрэг, бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, бататгах түвшний Олон нийтийн харилцаа гэсэн сургалтын хөтөлбөрт суралцсан байх шаардлагатай. Суралцсаны дараа бататгах түвшний Төр, хувийн хэвшлийн түншлэл сургалтын хөтөлбөр болон ахисан түвшний хөтөлбөрт Гомдлын менежмент сургалтын хөтөлбөрт хамрагдаж болно.

**“АЛБАН БИЧИГ, ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Албан бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах арга зүй”
- ✓ **Зорилго:** Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох хурлаас батлан гаргах баримт бичгийг эрх зүйн үндэслэлтэйгээр, төрийн албан ёсны хэлний хэм хэмжээнд нийцүүлэн найруулан бичих, баримт бичгийг оновчтой зохион бүрдүүлэх чадвараа нэмэгдүүлэх боломжтой.
- ✓ **Зорилтот бүлэг:** Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, төлөөлөгчид, нарийн бичгийн дарга нар, ажлын албаны албан хаагчид
Агуулга: Албан бичгийн найруулгын шаардлага; Албан бичгийг бүтцийн дагуу боловсруулах арга зүй; Захирамжлалын баримт бичиг зохион бүрдүүлэхэд тавигдах шаардлага; Захирамжлалын баримт бичгийг эрх зүйн болон стандартын шаардлагад нийцүүлэн боловсруулах арга зүй.

Сэдэв 1. Албан бичиг боловсруулах аргачлал

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Албан бичгийн бүтэц, найруулгын онцлог

Сэдэв 2. Албан бичгийн найруулга

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, дасгал ажил

Сэдвийн агуулга: Албан бичгийн найруулгад тавигдах шаардлага

Сэдэв 3. Захирамжлалын баримт бичигт тавигдах шаардлага

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Захирамжлалын баримт бичгийг зохион бүрдүүлэхэд тавигдах эрх зүйн болон стандартын үндсэн шаардлагууд

Сэдэв 4. Захирамжлалын баримт бичиг боловсруулахад анхаарах зүйлс

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Дасгал, кейс, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Шийдвэрийн төсөл боловсруулах аргачлал, найруулгын онцлог

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, хэлэлцүүлэг, дасгал, кейс ажиллах

Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо: ИТХ-ын төлөөлөгчид нь хууль, тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд баримт бичгийг батлан гаргах бөгөөд дараах хөтөлбөрүүдтэй уялдах боломжтой.

- “ИТХ-ын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт”
- “Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт”
- “Орон нутгийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах нь”
- “ИТХ-ын ёс зүй ба ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”